



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/242

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн “Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨААТҮГ-аас дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлаар хийгдсэн зам талбайн тохижилт болон бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга

М.Навчаа

Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Гишүүд

Ц.Батжанцан

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Д.Аззаяа

Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсийн дарга

Б.Түвшинтөгс

Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Санхүүгийн тасгийн дарга

Засаг дарга

1-24 дүгээр хороо

Зураг төслийн компанийн төлөөлөл(Зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга

Г.Энхбаяр

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

2. Зам талбайн тохижилт болон бүтээн байгуулалтын ажлыг зохих хууль, тогтоомжийн дагуу хүлээн авахыг Ажлын хэсэг (М.Навчаа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ



1525010705